

LOW AND LOWER MIDDLE INCOME 67 COUNTRIES

1. BGD	Bangladesh	40. CHL	Chile
2. BEN	Benin	41. COL	Colombia
3. BFA	Burkina Faso	42. DOM	Dominican Republic
4. BDI	Burundi	43. ECU	Ecuador
5. CMR	Cameroon	44. EGY	Egypt
6. CAF	Central African Republic	45. SLV	EL Savador
7. TCD	Chad	46. FJI	Fiji
8. ZAR	Congo, Dem. Rep	47. GTM	Guatemala
9. COG	Congo, Rep	48. GUY	Guyana
10. CIV	Cote d'Ivoire	49. HND	Honduras
11. GMB	Gambia, The	50. IDN	Indonesia
12. GHA	Ghana	51. IRN	Iran, Islamis Rep
13. GNB	Guinea-Bissau	52. JAM	Jamaica
14. IND	India	53. JOR	Jordan
15. KEN	Kenya	54. MAR	Morocco
16. LSO	Lesotho	55. PRY	Paraguay
17. LBR	Liberia	54. PER	Peru
18. MDG	Madagascar	57. PHL	Philippines
19. MWI	Malawi	58. WSM	Samoa
20. MLI	Malta	59. ZAF	South Africa
21. MRT	Mauritania	60. LKA	Sri Lanka
22. NPL	Nepal	61. SUR	Suriname
23. NIC	Nicaragua	62. SWZ	Swaziland
24. NGA	Nigeria	63. SYR	Syrian Arab Republic
25. PAK	Pakistan	64. THA	Thailand
26. PNG	Papua New Guinea	65. TUN	Tunisia
27. RWA	Rwanda	66. TUR	Turkey
28. SEN	Senegal	67. URY	Uruguay
29. SLE	Sierra Leone		
30. SLB	Solomon Island		
31. SDN	Sudan		
32. SUR	Suriname		
33. SWZ	Swaziland		
34. TGO	Togo		
35. ZMB	Zambia		
36. ZWE	Zimbabwe		
37. DZA	Algeria		
38. BOL	Bolivia		
39. BRA	Brazil		

14

ЭДИЙН ЗАСГИЙН БИЧВЭРҮҮДИЙГ АНГЛИ ХЭЛНЭЭС
МОНГОЛ ХЭЛ РҮҮ ХӨРВҮҮЛЭХ АСУУДАЛД

Ц.Баярмаа

Дэлхий даяарчилагдаж буй үйл явцын нэг тод илрэл нь олон оронд англи хэлийг сурах зайлшгүй хэрэгцээ гарч ирж буй явдал юм. Мэдээллийн технологийн энэ эрин үед шаардлагатай мэдээллээ олж авах, боловсруулах болон дүн шинжилгээ хийхэд англи хэлний багтай мэдлэг, тухайлбал, бичгийн хэлийг сайтар эзэмших шаардлага боловсролтой хүн бүрт тавигдаж байна.

Бизнесийн англи хэлний хичээлийн хүрээнд оюутнуудын англи хэл дээр хэвлэгдсэн эдийн засгийн бичвэрүүдийг орчуулсан байдлыг дүгнэхэд (сүүлийн 2 жилийн байдлаар) өгүүлбэрийн бүтцийг зөв тодорхойлох явдал тухайн өгүүлбэрийн утгыг үнэн зөв хөрвүүлж гаргахын 60%, үг хэллэг буюу нэр томъёог зөв оноох - 20%, уг гаргасан утгыг монгол хэлээр зөв найруулж илэрхийлэх - 20% ийг эзэлдэг болох нь харагдсан юм.²⁶ Иймд англи хэлээр мэргэжлийн ном зохиол, сэтгүүл ашиглаж сурахын нэг гол үндэс нь өгүүлбэрийн бүтцийг зөв тодорхойлох явдал юм.

Аливаа хэлний хавсарсан өгүүлбэрүүд нэг гол гишүүн өгүүлбэр, нэг буюу түүнээс дээш захирагдах гишүүн өгүүлбэр, хавсарсан нийлмэл өгүүлбэрүүд нь хоёр буюу түүнээс дээш гол гишүүн өгүүлбэрүүд, мөн нэг буюу түүнээс дээш захирагдах гишүүн өгүүлбэрүүдтэй байдаг. Иймд эдгээрийн ялгааг сайн мэдэхгүйгээс мэргэжлийн англи ном, сэтгүүл ашиглаж буй оюутнууд, эрдэмтэн судлаач болон багш нарт өгүүлбэрийн утгыг ойлгоход хүндрэл учирч байдаг.

Иймд эдгээр өгүүлбэрүүдийн бүтцийн ялгааг эдийн засгийн бичвэрүүдээс жишээ өгүүлбэрүүд авч, задлан шинжилж тайлбарлахыг зорилоо.

²⁶ МУИС-ийн ЭЗС-ийн 2-р дамжааны оюутнуудын дунд явуулсан судалгаа, 2006-2007.

Захирагдах гишүүн өгүүлбэрүүд

Англи хэлний dependent clause буюу захирагдах гишүүн өгүүлбэр нь захирч буй өгүүлбэрийн санааг гүйцээж гаргах үүрэг бүхий өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүнээс бүрдсэн бүлэг үгс бөгөөд дангаараа гүйцэд утга гаргах чадваргүй байдаг.

Гишүүн өгүүлбэрүүдийг захирч буй гол өгүүлбэртээ холбогдсон байдлаас нь хамааруулж дараах гурван төрлөөр ангилна:

- Тодотгол гишүүн өгүүлбэр (Adjective clause)
- Нэр гишүүн өгүүлбэр (Noun clause)
- Үйл хавсрал гишүүн өгүүлбэр (Adverb clause)

I. Тодотгол гишүүн өгүүлбэр (Adjective clause)

Энэ нь захирч буй өгүүлбэрийнхээ өгүүлэгдэхүүн болон тусагдахуун гишүүний аль нэгийг тодотгож, түүнийг дэлгэрүүлэх үүрэгтэй байдаг.

Жишээ-1

*The economic system is the mechanism that *brings together natural resources, the labour supply, technology and the necessary entrepreneurial and management talents.*²⁷

Гол гишүүн өгүүлбэр: *The economic system is the mechanism;*

Тодотгол гишүүн өгүүлбэр: *That brings together natural resources, the labour supply, technology and the necessary entrepreneurial and management talents.*

Энд *that* нь холбох төлөөний үг бөгөөд гол өгүүлбэрийн тусагдахуун болох *the mechanism* гэдэг үгийг тодотгол гишүүн өгүүлбэрт төлөөлж, тус гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн гишүүний үүргийг давхар гүйцэтгэн гол гишүүн өгүүлбэрийг захирагдах гишүүн өгүүлбэртэй холбож байна. Уг тодотгол гишүүн өгүүлбэр нь гол гишүүн өгүүлбэрийн *the mechanism* гэсэн нэр үгийг тодотгон, нэмэлт мэдээлэл өгч бүхэлдээ “*ямар механизм*”? гэсэн асуултанд хариулагдаж байна.

Тодотгол гишүүн өгүүлбэрийг тодотгуулж буй нэр үгийн өмнө оруулж орчуулна:

Орчуулга:

Эдийн засгийн тогтолцоо нь байгалийн нөөцүүд, хөдөлмөрийн нийлүүлэлт, болон технологийг аж ахуй эрхлэх болон удирдахад шаардагдах авъяас чадваруудтай уялдуулах механизм юм.

²⁷ Stewart Ramsey, American Economy, 1992, p.12

*Bring A and B together гэдэг хэлц үг А болон В-г хооронд нь эвлэрүүлэх, эв зүйтэй болгох гэсэн утгатай байдаг бөгөөд энэ өгүүлбэр дээр уялдуулах гэсэн үгийг хэрэглэвэл тохиромжтой байна.

Жишээ-2

*The respective inverse demand function is $P_T(Q, x)$, where x denotes the sold quantity.*²⁸

Гол өгүүлбэр: *The respective inverse demand function is $P_T(Q, x)$*

Тодотгол гишүүн өгүүлбэр: *where x denotes the sold quantity.*

Энд *where* нь холбох төлөөний үг бөгөөд гол өгүүлбэрийн $P_T(Q, x)$ гэсэн функц дэх шинжийг захирагдах гишүүн өгүүлбэрт гаргаснаар хоёр өгүүлбэрийг холбож, уг функцийн талаар нэмэлт мэдээлэл хүргэж байна.

Орчуулга:

Харгалзах эрэлтийн урвуу функц нь $P_T(Q, x)$ функц байх агаад x хувьсагч нь зарагдсан барааны тоо хэмжээг илэрхийлнэ.

Жишээ-3 Хоёр захирагдах гишүүн өгүүлбэртэй хавсарсан өгүүлбэр

*Regulation is usually considered necessary in areas where private enterprise has been granted a monopoly, such as in electric or local telephone service, or in other areas where there is limited competition, as with the railroads.*²⁹

Гол өгүүлбэр: 1. *Regulation is usually considered necessary in areas ...or in other areas*

Гишүүн өгүүлбэр: 1. *where private enterprise has been granted a monopoly, such as in electric or local telephone service*
2. *where there is limited competition, as with the railroads.*

Where нь холбох төлөөний үг бөгөөд гол өгүүлбэрийн *in areas* гэсэн хавсрал хэлцийн гүйцээврийг захирагдах гишүүн өгүүлбэрт төлөөлж байна.

Орчуулга:

Зохицуулалтыг ихэвчлэн эрчим хүч, орон нутгийн үүрэн холбоо гэх мэт хувийн хэвшлийн компаниуд болох монополь эрх олгогдсон салбаруудад, эсвэл

²⁸ Roman Inderst and Greg Shaffer, □Retail mergers, buyer power and product variety□, The Economic Journal, January 2007.vol.117 N516 p.47

²⁹ Stewart Ramsey, American Economy, 1992, p.17

төмөр зам мэт өрсөлдөөн хязгаарлагдмал байдаг салбаруудад хийх шаардлагатай гэж үздэг.

Жишээ-4 Энд өөр нэг ижил жишээ авч үзье.

*It is possibly in the UK where competition authorities have started to look most seriously into retailer buyer power, and, as a result of this, the Code of Practice, which is supposed to govern the relationship of the UK's top five retailers with their suppliers, was formulated.*³⁰

Гол өгүүлбэр: *It is possibly in the UK the Code of Practice was formulated.*

Гишүүн өгүүлбэрүүд:

1. where competition authorities have started to look most seriously into retailer power;
2. which is supposed to govern the relationship of the UK's top 5 retailers with their suppliers

Энд 1-р гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрт байр зааж буй UK-г тодотгож, нэмэлт мэдээллээр дэлгэрүүлж өгч байгаа тул гишүүн өгүүлбэрийг UK-ийн өмнө оруулж орчуулна.

2-р гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрийн the Code of Practice-ийг тодотгож дэлгэрүүлж байгаа тул монгол хэл рүү орчуулахдаа өмнө нь тодотгол болгож оруулна.

As a result of this холбоос нь тухайн өгүүлбэрүүдийг шалтгаан, үр дагавраар уялдуулан холбожээ.

Орчуулга:

Өрсөлдөөнийг зохицуулах байгууллагууд жижиглэнгийн худалдан авагчдийн худалдан авах чадавхийг нухацтай анхаарч эхэлсэн Нэгдсэн Вант Улсад магадгүй, үүнээс улбаалаад, тус улсын топ таван жижиглэнгийн компани болон тэдний нийлүүлэгчдийн харилцан үйл ажиллагааг зохицуулах үүднээс "Үйл ажиллагааны журам"-ыг боловсруулан гаргасан байж болох юм.

Жишээ-5 Хураангуйлсан тодотгол гишүүн өгүүлбэр

Зарим тодотгол гишүүн өгүүлбэрүүд хураангуй хэлбэртэй байдаг:

*These factors, coupled with rapid technological change, prompted President Jimmy Carter to reduce regulation of the transportation and communication industries in the 1970s.*³¹

³⁰ Roman Inderst and Greg Shaffer, "Retail mergers, buyer power and product variety", The Economic Journal, January 2007, vol.117 N516 p.45

³¹ Stewart Ramsey, American Economy, 1992, p.17

Гол өгүүлбэр: *These factors prompted President Jimmy Carter to reduce regulation of the transportation and communication industries in the 1970s.*

Гишүүн өгүүлбэр: *coupled with rapid technological change*

Тус гишүүн өгүүлбэрийн дэлгэрэнгүй хэлбэр нь *which are coupled with rapid technological change* бөгөөд гол өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн гишүүн *these factors* –ыг тодотгож дэлгэрэнгүй мэдээлэл өгч байна. *Which* гэсэн холбох төлөөний үгийг үйл үг *to be* –ийн *passive* хэрэглээтэй хамт орхин хураангуйлж болдог.

Орчуулга:

Технологийн хурдацтай хөгжилтэй хосолсон эдгээр хүчин зүйлүүд нь 1970-аад оны үед зам тээвэр болон харилцаа холбооны салбаруудад зохицуулалтыг бууруулах шаардлагатай болсныг ерөнхийлөгч Жимми Картерт сануулсан байна.

II. Үйл хавсрал гишүүн өгүүлбэр (Adverb clause)

Өгүүлбэрийн үйл хавсрал буюу байц гишүүний нэг адил хавсрал гишүүн өгүүлбэр нь захирч буй гол өгүүлбэрийнхээ үйлийг хэзээ, хэрхэн, хаана, яагаад болсон талаар дэлгэрүүлж, мэдээлэл өгөх үүрэгтэй байдаг. Иймд энэ төрлийн гишүүн өгүүлбэрийг:

- Time -үйлийн цаг заасан (when, whenever, before, after, since, while, until, as, as soon as)
- Place - байр заасан (where, wherever)
- Cause- шалтгаан заасан (because, since, as, in order that)
- Purpose- зорилго заасан (so that, so)
- Manner- төлөв байдал заасан (as, as if, as though)
- Result- үр дагавар заасан (so... that, such ... that)
- Condition- нөхцөл заасан (if, unless, provided that, on condition that)
- Concession- зөвших (although, though, even if, even though)
- Comparison- харьцуулах (than, as) гэж ангилдаг.

Энд бүгдийг дурьдах боломжгүй тул орчуулгад эргэлзээ төрүүлж болзошгүй зарим нэг үйл хавсрал гишүүн өгүүлбэрийг жишээн дээр тайлбарлъя.

Жишээ-6 (Шалтгаан заасан)

*As shelf space at each outlet is scarce, each retailer must limit its range of product offerings.*³²

³² Roman Inderst and Greg Shaffer, "Retail mergers, buyer power and product variety", The Economic Journal, January 2007, vol.117 N516 p.47

Гол өгүүлбэр: *Each retailer must limit its range of product offerings.*

Гишүүн өгүүлбэр: *as shelf space at each outlet is scarce*

Энд гол өгүүлбэр жижиглэнгийн худалдааны дэлгүүр бүр зарж буй барааныхаа нэр төрлийг хязгаарлах ёстой болсныг өгүүлэх бөгөөд гишүүн өгүүлбэр нь яагаад гэдэг шалтгааныг хэлж өгч байна.

Орчуулга:

Жижиглэнгийн барааны дэлгүүр бүрийн барааны тавиурын зай хомс учраас дэлгүүр тус бүр борлуулж буй барааныхаа нэр төрлийг хязгаарлах ёстой болжээ.

Энд мөн *since* шалтгаан заасан өгүүлбэр авч үзье:

Жишээ-7 (Шалтгаан заасан)

*Since real balances provide transaction services, they should be maximized by making the opportunity cost of holding money, the nominal interest rate, as low as possible.*³³

Гол өгүүлбэр: *they should be maximized by making the opportunity cost of holding money, the nominal interest rate, as low as possible.*

Гишүүн өгүүлбэр: *Since real balances provide transaction services*

Энд *since*-ийг шалтгаан заасан утгаар хэрэглэж байгаа тул *учраас, учир иймд, тийм учраас, тул* гэх мэтчилэн орчуулна.

Орчуулга:

Бодит тэнцлүүд нь гүйлгээний үйлчилгээ явуулах боломж олгодог тул мөнгө эзэмшсэнээр бий болох алдагдсан боломжийн өртөг буюу нэрлэсэн хүүгийн хэмжээг аль болох бага түвшинд байлгах замаар бодит тэнцлийг ихэсгэх хэрэгтэй.

Жишээ- 8 (Нөхцөл заасан)

Англи хэлэнд нөхцөл заасан үйл хавсрал гишүүн өгүүлбэрийн хэд хэдэн төрлийн холбоос үг байдаг бөгөөд тэдгээрийн заримыг шинжлэх ухааны зохиолын найруулгад түлхүү хэрэглэх нь бий. Жишээлбэл:

³³ Aleksander Berentsen, Guillaume Rocheteau and Shouyoung Shi, □Friedman meets Hosios: efficiency in search models of money□, The Economic Journal, Vol-117, N 516, Jan, 2007, p. 174

*If a good with characteristics Q is sold at price p, the demand at outlet r equals Dr (Q, p).*³⁴

Гол өгүүлбэр: *the demand at outlet r equals Dr (Q, p).*

Гишүүн өгүүлбэр: *If a good with characteristics Q is sold at price p*

Орчуулга:

Хэрэв Q шинж чанартай бүтээгдэхүүн p үнээр зарагдсан бол тус нэрийн дэлгүүр дэх r эрэлт Dr (Q, p) байх болно.

Жишээ- 9 (нөхцөл заасан)

*He will sign the contract provided that we pay him a bonus.*³⁵

Гол өгүүлбэр: *He will sign the contract*

Гишүүн өгүүлбэр: *provided that we pay him a bonus*

Энд ямар нөхцөлд гол өгүүлбэрийн эзэн гэрээнд гарын үсэг зурах гэж байгааг гишүүн өгүүлбэр тодотгож байна. *Provided that*-ыг монгол хэлэнд хэрэв, тэр тохиолдолд хэмээн хөрвүүлнэ.

Орчуулга:

Хэрэв бид түүнд шан өгвөл тэр гэрээнд гарын үсэг зурна.

Зарим нөхцөл заасан үйл хавсрал гишүүн өгүүлбэрүүдэд *if* хэмээх түгээмэл нөхцөл заасан холбоос үгийг хэрэглэхгүй байх нь бий. Үүний оронд гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн ба өгүүлэгдэхүүний байрыг сольж хэрэв гэсэн утгыг гаргадаг.

Were John here now (= if John were here now) he would explain the whole matter.

Хэрэв Жон одоо энд байсан бол асуудлыг бүхэлд нь тайлбарлаад өгөх байсан.

Had you asked me = (if you had asked me), I would have told you the answer.

Надаас асуусан бол би хариуг нь хэлээд өгөх байсан шүү дээ.

Should anyone call, please take a message.

Хэрэв хүн утасдвал юу дамжуулахыг нь асуучихаарай.

Жишээ- 10. (зорилго заасан)

³⁴ Roman Inderst and Greg Shaffer, □Retail mergers, buyer power and product variety□, The Economic Journal, January 2007.vol.117 N516 p.47

³⁵ Donald W.Emery, John M.Kierzek, Peter Lindblom, English Fundamentals New York, 1992 p.62

*The reasoning is analogous, if the opposite of (3) holds, so that only good B is stocked at both outlets.*³⁶

Жишээ авсан өгүүлбэр маань хоёр үйл хавсрал захирагдах гишүүн өгүүлбэртэй хавсарсан өгүүлбэр байна.

Гол өгүүлбэр: *The reasoning is analogous*

Гишүүн өгүүлбэр: 1. (нөхцөл заасан) *if the opposite of (3) holds*

2. (зорилго заасан) *so that only good B is stocked at both outlets.*

Орчуулга:

Хэрэв хоёр нэрийн барааны дэлгүүрийн аль алинд зөвхөн B бараа зарагдаж байх нөхцөл болох (3) тэнцэтгэл биш нь эсрэгээрээ биелэгдэж байвал уг тайлбар аналог байна.

Жишээ- 11 (үр дагавар заасан)

*The workmen made such a racket that I got a headache.*³⁷

Гол өгүүлбэр: *The workmen made such a racket*

Гишүүн өгүүлбэр: *that I got a headache.*

Орчуулга:

Ажилчид маш их чимээ шуугиан гаргаснаас болж миний толгой өвдөв.

Жишээ- 12 (*'as' холбоос үгтэй цаг заасан)

*The slope of each indifference curve gets steadily flatter as we move to the right.*³⁸

Гол өгүүлбэр: *The slope of each indifference curve gets steadily flatter*

Гишүүн өгүүлбэр: *as we move to the right.*

*'As' холбоос үг нилээд олон төрлийн гишүүн өгүүлбэрт хэрэглэгддэг тул өгүүлбэрийн утгыг гаргахад төөрөгдөлд хүргэх магадлалтай байдаг. Иймд захирч буй өгүүлбэртээ ямар утгаар холбогдож буйг тогтоохдоо ямар асуултанд хариулагдаж буйгаар нь тодорхойлоход хялбар байдаг. Дээрх өгүүлбэрт ямар үед, хэдийд муруй тус бүрийн налалт илүү их хэвтээ шинжтэй

³⁶ Roman Inderst and Greg Shaffer, "Retail mergers, buyer power and product variety", *The Economic Journal*, January 2007, vol.117 N516 p.51

³⁷ C. E. Eckersley and J.M. Eckersley, *A comprehensive English Grammar*, Longman, 1993, p.339

³⁸ C St I Yates, *Economics*, (English for academic purposes series) Prentice Hall, p. 103

болж байна вэ? гэсэн асуултанд уг үйл хавсрал гишүүн өгүүлбэр маань хариулт өгч байгаа тул цаг заасан гишүүн өгүүлбэр байна.

Орчуулга:

Ялгаагүйн муруй тус бүрийн налалт нь баруун тийш чиглэх тусам тогтвортойгоор илүү их хэвтээ шинжтэй болж байна.

Жишээ- 13 (төрх байдал болон цаг заасан)

Тус өгүүлбэр нь 2 үйл хавсрал гишүүн өгүүлбэртэй хавсарсан өгүүлбэр байна.

*Whenever economists speak of the demand elasticity they mean the price elasticity of demand as we have defined it above.*³⁹

Гол өгүүлбэр: *they mean the price elasticity of demand*

Гишүүн өгүүлбэр: 1. (цаг заасан) *Whenever economists speak of the demand elasticity*

2. (төрх байдал заасан) *as we have defined it above.*

Цаг заасан үйл хавсрал гишүүн өгүүлбэр нь хэзээ? гэсэн асуултанд бүхэлдээ хариулагдах бөгөөд байдал заасан гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрийн үйл ямар байдлаар, хэрхэн яаж хийгдсэнийг илэрхийлж байдаг тул бүхэлдээ яаж? хэрхэн? ямар байдлаар? гэсэн асуултуудад хариулагдаж байдаг.

Орчуулга:

Эдийн засагчид эрэлтийн мэдрэмжийн талаар хөндөж байвал бидний өмнө өгүүлснээр тэд эрэлтийн үнийн мэдрэмжийн талаар л ярьж буй хэрэг юм.

III. Нэр гишүүн өгүүлбэр (Noun clause)

Нэр гишүүн өгүүлбэр нь үйл үгэнд тусагдахуун, өгүүлэгдэхүүний үүрэг гүйцэтгэж, хэн? юу? гэсэн асуултанд бүхэлдээ хариулагдаж явдаг бүлэг үгс болно.

Нэр гишүүн өгүүлбэр нь үйл үгийн:

- тусагдахуун
- өгүүлэгдэхүүн
- угтварын тусагдахууны үүрэг тус тус гүйцэтгэдэг.

Жишээ- 14 (үйл үгийн тусагдахууны үүрэг гүйцэтгэсэн)

*Table 1-3 shows how much of each good can be produced per week.*⁴⁰

³⁹ C St I Yates, *Economics*, (English for academic purposes series) Prentice Hall, p. 103

Гол өгүүлбэр: *Table 1-3 shows*

Гишүүн өгүүлбэр: *how much of each good can be produced per week*

Тус нэр гишүүн өгүүлбэр нь *shows what?* гэсэн асуултанд хариулагдаж *shows* үйл үгэнд шууд тусгагдахууны үүрэг гүйцэтгэж байна.

Орчуулга:

Хүснэгт 1-3-т бараа тус бүр долоо хоногт хэр зэрэг хэмжээгээр үйлдвэрлэгдэх боломжтой байгааг үзүүлэв.

Жишээ- 15 (үйл үгэнд өгүүлэгдэхүүний үүрэг гүйцэтгэсэн)

*What distinguishes these economists is the segment of economic life in which they are interested.*⁴¹

Энэ өгүүлбэрт нэр гишүүн өгүүлбэр болон тодотгол гишүүн өгүүлбэр орсон байна. Нэр гишүүн өгүүлбэр болох *What distinguishes these economists* нь гол захирах өгүүлбэрийн үйл үг болох *is* –ийн өгүүлэгдэхүүний үүрэг гүйцэтгэж байна.

Гол өгүүлбэр: *What distinguishes these economists is the segment of economic life*
Гишүүн өгүүлбэрүүд: 1. (нэр гишүүн өгүүлбэр) *what distinguishes these economists*

2. (тодотгол гишүүн өгүүлбэр) *in which they are interested*

Орчуулга:

Эдгээр эдийн засагчдыг ялгаатай болгож буй зүйл бол тэдний сонирхдог эдийн засгийн амьдралын тухайн салбар юм.

Жишээ- 16 (үгтварын тусгагдахуун)

*Normative economics makes prescriptions about what should be done.*⁴²

Гол өгүүлбэр: *Normative economics makes prescriptions*

Нэр гишүүн өгүүлбэр: *about what should be done*

Нэр гишүүн өгүүлбэр *about what should be done* нь үгтвар үг *about-* ын тусгагдахууны үүргээр хэрэглэгдэж гол өгүүлбэртээ захирагдаж байна.

Орчуулга:

Норматив эдийн засаг нь юу хийх ёстой болохыг авч үздэг.

⁴⁰ C St I Yates, Economics, (English for academic purposes series) Prentice Hall, p.12

⁴¹ C St I Yates, Economics, (English for academic purposes series) Prentice Hall, p.29

⁴² C St I Yates, Economics, (English for academic purposes series) Prentice Hall, p.35

Дүгнэлт

Аливаа хэлний дүрмийг эрэмбэ дараатай судлах нь тус хэлийг төгс сайн сурах үндэс суурь болдог. Бүх хэлнүүдэд нийтлэг шинж байдаг тул тухайн хэлийг эх хэлтэйгээ харьцуулан судлавал илүү их үр дүнтэй байдаг. Иймд дэлхий нийтийн хэл болоод байгаа англи хэлийг илүү сайн сурахын тулд тус хэлний өгүүлбэрийн бүтцийг эх хэлнийхээ өгүүлбэрийн бүтэцтэй харьцуулан үзэж, англи хэлнээс монгол хэл рүү, монгол хэлнээс англи хэл рүү аль болох их өгүүлбэр хөрвүүлэн дадлага хийвэл үр дүнтэй бөгөөд суралцагчийн хэлний мэдлэг тэр хэмжээгээр батжиж байдаг.

Монгол Улсын Их Сургууль

Эдийн засгийн сургууль

Англи хэлний төв

2007-11-27

Улаанбаатар хот

References

Аким Г, *Орчуулгын санг уудлахад*, Улаанбаатар, 1984

Aleksander Berentsen, Guillaume Rocheteau and Shouyoung Shi, 'Friedman meets hosios: efficiency in search models of money', The Economic Journal, Vol-117, N 516, Jan, 2007

Bayasgalan R, B.Gard, B.Telmen, *English-Mongolian Mongolian-English Economics Dictionary*, Manchester, Ulaanbaatar, 1997

Betty Schramper Azar, *Understanding and using English Grammar*, Prentice Hall, 1989

Donald W.Emery, John M.Kierzek, Peter Lindblom, *English Fundamentals*, New York, 1992

Eckersley C. E. and J.M. Eckersley, *A comprehensive English Grammar*, Longman, 1993

John Black, *Oxford dictionary of Economics*, Oxford university press, 2002

Roman Inderst and Greg Shaffer, 'Retail mergers, buyer power and product variety', The Economic Journal, January 2007.vol.117 N516

Sumiya Ts, *English (Syntax: rules, exercises and tests)*, Ulaanbaatar, 1996

Сүхбаатар Ц, *Монгол хэлний найруулга зүй*, Улаанбаатар, 1998

Yates. C St I, *Economics, (English for academic purposes series)* Prentice Hall, 1997